



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Г Ерөнхий боловсролын сургуулийн багш
нарын сургалт, семинар явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33,5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2009 оны 05, 2017 оны 289 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын бие бялдрын хөгжил, хөдөлгөөний эвслийг сайжруулах, биеийн тамирын багш мэргэжилтнүүдийг мэдээллээр хангах, ур чадварыг дээшлүүлэх “Хөдөлгөөн-Эрүүл мэнд” сэдэвт сургалт, семинарыг 2019 оны 01 дүгээр сарын 21-25-ны өдрүүдэд Нийслэлийн Засаг захиргааны V байрны “иргэний танхим”-д, болон Нийслэлийн Засаг даргын тамгын газрын спорт зааланд зохион байгуулсугай.

2. Сургалт, семинарыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, хичээл заах багш нарын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт, семинарт шаардагдах 1.800.000 /нэг сая найман зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны сургалт, семинарын зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-т зөвшөөрсүгэй.

4. Сургалт, семинарыг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтэс /А.Болдмаа/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны
даргын 2019 оны *ногдун сар* сарын *18*-ны өдрийн
А/03 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Ерөнхий боловсролын сургуулийн
багш нарын сургалт, семинарын төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Багшийн ажлын мөнгө: 5 хоног х 30 цаг х 30.000 төг	900.000 төг
2.	Заалны хөлс:	300.000 төг
3.	Бичиг хэргийн зардал /цай кофе/	200.000 төг
4.	Гарын авлага, сурталчилгаа:	300.000 төг
5.	Видео бичлэг, зураг, хальс анонс	300.000 төг
6.	Сертификат хэвлүүлэх	100.000 төг
Нийт дүн		1.800.000 төг

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2019 оны...*нодун*... сарын *18*-ны өдрийн *А/03* дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Ерөнхий боловсролын багш, арга зүйчдийн сургалт, семинар, хичээл заах багш нарын бүрэлдэхүүн

- | | |
|------------------|---|
| 1. А.Болдмаа | НБТСХорооны хэлтсийн дарга |
| 2. Ц.Март | Монголын Гимнастикийн холбооны зөвлөх багш |
| 3. А.Болорцэцэг | Монголын Гимнастикийн холбооны зөвлөх багш |
| 4. Б.Түвшинбаяр | НБТСХорооны мэргэжилтэн |
| 5. Ж.Чулуунцэцэг | ХУД-ийн 34-р сургуулийн багш |
| 6. Ч.Амгалан | “Тэгш хийморь” ТББ тэргүүн |
| 7. Х.Оюунбилэг | Монголын Биеэ тэтгэх хийн дасгалын холбооны тэргүүн |
| 8. Б.Оргилмаа | МБФНХ-ны хүүхдийн фитнесийн зөвлөлийн дарга |
| 9. З.Галхүү | Монголын Бадминтон сонирхогчдын холбооны менежер |